III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Байгаль орчны шинжилгээний төв лабораторийн шинэ барилгын цахилгаан, дулаан, цэвэр бохир ус, холбооны гадна шугам сүлжээний зураг, төсвийн хэмжээг тооцоолох ажлын даалгавар

№	Зураг төсөв боловсруулах үндэслэл	Байгаль орчны шинжилгээний төв лабораторийн шинэ барилгын Хот байгуулалт, хөгжлийн газрын МЗХ2024/00-083 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавар
1	Барилга байгууламжийн байршил, газар олголтын шийдвэр	Улаанбаатар Хан-Уул 23-р хороо 0 тоот, Богдхан уулын ДЦГ тусгай хамгаалалттай газар нутаг, 27-р нэгж хороолол, Арцатын ам /17100/ бүсчлэлд Газар ашиглах эрхийн 2022-06-07-ны нэгж талбарын 1781113022 дугаартай гэрчилгээтэй
2	Зориулал, хүчин чадал: /Үйлчилгээний нэр төрөл/	Байгаль орчны шинжилгээний төв лабораторийн шинэ барилга
3	Зураг, төсвийн бүрдэл	- Барилгын дулааны шугамын холболтын зураг болон төсөвт өртгийг “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн тушаалаар олгосон № 574/2024 дугаартай техникийн нөхцөлийн дагуу гүйцэтгэж тооцоолох; - Барилгын цахилгааны холболтын зураг болон төсөвт өртгийг “Улаанбаатар цахилгаан түлгээх сүлжээ” ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 01/06381/24 дугаартай техникийн нөхцөлийн дагуу гүйцэтгэж тооцоолох; - Барилгын холбооны сувагчлал хийх зураг болон төсөвт өртгийг “Холбоо сүлжээний газар” ХХК-ийн захирлын 2024 оны 12 дугаар сарын 16-ны тушаалаар олгосон D-U2024/1044 дугаартай техникийн нөхцөлийн дагуу гүйцэтгэж тооцоолох; - Барилгын цэвэр, бохир усны шугамын холболт хийх зураг болон төсөвт өртгийг “Ус сувгийн удирдах газрын” Техникийн нөхцөл олгох комиссын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрээр олгосон 0770/24 дугаартай техникийн нөхцөлийн дагуу гүйцэтгэж тооцоолох.
4	Зураг төсвийн үе шат, хугацаа	Зураг, төсөв боловсруулах 1 үе шаттай. Гэрээнд заасан хугацаанд
5	Санхүүжилтийн эх	Улсын төсөв

	үүсвэр	
6	Зураг, төсөв зохиогч байгууллага	Барилга хот байгуулалтын яамны сайдын тушаалаар батлагдсан Хот байгуулалтын баримт бичиг, барилга байгууламжийн зураг, төсөв боловсруулах тусгай зөвшөөрөл олгох журмын барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, төсөв тооцоолох тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий хуулийн этгээд
7	Зөвлөхийн баримт бичгийн баталгаажуулалт	Байгаль орчны шинжилгээний төв лабораторийн шинэ барилгын цахилгаан, дулаан, цэвэр бохир ус, холбооны гадна шугам сүлжээний зураг, төсөвт Барилгын тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагаар баталгаажуулж зураг, төсөв өртөгт магадлал хийлгэсэн байна.
8	Галын аюулгүй байдлын нөхцөл	Барилга байгууламжийн галын аюулгүй байдал БНбД21-01-02, Барилга байгууламжийн зураг, төсөв зохиох галын аюулгүй норм БНбД21-02-02-ийн холбогдох шаардлагуудыг хангасан байна.
9	Холбогдох материал	- Хот байгуулалт, хөгжлийн газрын МЗХ2024/00-083 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавар; - “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн 2024 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн №574/2024 дугаартай техникийн нөхцөл; - “Улаанбаатар цахилгаан түлгээх сүлжээ” ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 01/06381/24 дугаартай техникийн нөхцөл; - “Холбоо сүлжээний газар” ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн D-U2024/1044 дугаартай техникийн нөхцөл; - “Ус сувгийн удирдах газрын” Техникийн нөхцөл олгох комиссын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 0770/24 дугаартай техникийн нөхцөл; - Байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт; - Газар ашиглах эрхийн гэрчилгээ.

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР
Г.БАТЗОРИГ

АРХИТЕКТУР ТӨЛӨВЛӨЛТИЙН ДААЛГАВАР

2024 оны 03 сарын 11 өдөр | Дугаар: **МЗХ2024/00-083** | Улаанбаатар хот

1	Газар олголтын захирамжийн дугаар, олгогдсон газрын байршил, хэмжээ, үндэслэл	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/305 дугаар тушаалаар Хан-Уул дүүргийн 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт, Богдхан уулын ДЦГ тусгай хамгаалалттай газар нутаг, 27 дугаар нэгж хороолол, Арцатын ам /17100/ бүсчлэлд, Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлгийн зүүн урд талд байршуулан Аялал жуулчлал, сургалт судалгаа зориулалтаар ашиглах 1.3 га газар.
2	Барилга байгууламжийн нэр, зориулалт	**Байгаль орчин, аялал жуулчлалын яам** Байгаль орчны шинжилгээний төв лабораторийн барилга
3	Барилгажих талбайн хэмжээ, хүчин чадал (Барилгын бүрхцийн харьцаа)	2955.5 м^2 талбайд багтаана, Барилгын бүрхцийн харьцааны 0.4 үзүүлэлтийг баримтлан эзэмшил газрын 40%-аас дээшгүй талбайд барилгажуулна, Тагт, консоль, довжоо болон рампыг эдэлбэр газарт, төлөвлөлтийн хязгаарт багтаан нормоор тооцон төлөвлөнө. (BCR)
4	Барилгын төрөл, давхрын тоо, (давхар талбайн харьцаа)	Тухайлсан зураг төсөлтэй (зоорьтой) Давхар талбайн харьцааны 2.1 үзүүлэлтийг баримтлан 22494.9 м^2-аас хэтрүүлэхгүй төлөвлөнө. (FAR)
5	Дагаж мөрдөх ерөнхий төлөвлөгөөний бүсчлэл	Нисэх Яармаг орчмын орон сууцны хорооллын ерөнхий төлөвлөгөө, Дундаж давхрын орон сууцны бүс
6	Эдэлбэр газрын:	13828.0 м^2
	– Барилгажих талбай	2955.5 м^2 (ХБТХуулль 12.8)
	– Ногоон байгууламж, гадна тохижилт төлөвлөх талбай	Эдэлбэр газрын 20%-аас доошгүй талбай (ХБТХуулль 12.6.3)
	– Тоглоомын талбай, амрах талбай	БНбД 30-01-04-н 2 дугаар хүснэгтэд зааснаар (ХБТХуулль 12.6.3)
	– Авто зогсоол	БНбД 31-01-10-н 13 дугаар хүснэгтэд зааснаар, БНбД 30-01-04-н заавал мөрдөх 14 дүгээр хавсралтад зааснаар (ХБТХуулль 12.6.3), Эдэлбэр газарт багтаан газар доорх зогсоол төлөвлөх боломжтой. - Цахилгаан тээврийн хэрэгсэл цэнэглэх цэгийг нийт зогсоолын хүчин чадлаас хамааруулан 3%-д төлөвлөнө. - Унадаг дугуйн зам, зогсоол төлөвлөх, - Авто замын төлөвлөлтийг орчны байдал, төлөвлөлттэй уялдуулан хорооллын авто замтай холбох, орц гарцыг нэгтгэн төлөвлөх.
7	Талбайн ерөнхий төлөвлөгөө, тохижилтод тавигдах шаардлага	- "Нийслэлийн нутаг дэвсгэрт хашаа, хайс барих, ашиглах буулгах журам"-ын 4.1-т зааснаар төлөвлөн загвар зураг хийц, загварыг тусгах, - Гудамж замын улаан шугам, талбайн тохижилт, зам талбайд гэрэлтүүлэг хийж, явган хүний хөдөлгөөнд саад учруулахгүйгээр онцгой нөхцөлд ашиглах орц гарц төлөвлөх, - хяналтын камер төлөвлөх, зөвшөөрөлгүй хашаа барихгүй байх, - Зөвшөөрөлгүй хашаа барихгүй байх, барилгын түр хашааны өндөр 3 метр, хамгаалалтын торны өндөр 2 метр байна.

24 оны 03 сарын 11 өдөр

		- Орчинтой уялдуулж ногоон байгууламж болон авто зогсоол талбайн тохижилтын зургийг иж бүрэн боловсруулна.
8	Архитектур төлөвлөлтийн шаардлага	- Гадна тохижилтыг орчны барилга байгууламжуудтай уялдуулан нэгдсэн байдлаар төлөвлөх, - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орц гарц, пандусыг стандарт (MNS 6056:2009; 6055:2009) болон норм дүрэм (Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох норм БД 31-112-11)-н дагуу төлөвлөх, барилгын зураг төсөлд хийц архитектур төлөвлөлтийн шийдлийг бүрэн гаргах, - Төлөвлөж буй барилга орчмын гудамж замын зэрэглэлд тавигдах шаардлага, стандарттай нийцүүлэн барилгын гадна фасадыг цаг уурын онцлог /эрс тэс уур амьсгалтай хот/-т тохируулж барилгын чанар стандартад нийцсэн ачаалал даахуйц материал ашиглах, загвар зурагт өнгөний код, материалыг тодорхой тусгах, барилгын гадна фасадад барилгын дулаалгын хөөс, бусад шаардлага хангахгүй материал ашиглахгүй байх, - Барилгын хаяг рекламыг фасадын зурагт тодорхой тусгаж орц орчимд захиалагч, зураг төсөл зохиогч, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийн мэдээлэл бүхий мэдээллийг хүний харааны түвшинд байршуулж загвар зурагт зөвшилцөх, - Барилгын суурийг эдэлбэр газарт багтаах, одоо байгаа болон төлөвлөгдсөн барилгуудын гал тэсвэршилтийн зэргийг тооцож тохиромжтой хийцийг сонгон төлөвлөнө.
9	Хот төлөвлөлтийн онцгой нөхцөл	- Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний авто зам болон явган зам талбай, ногоон байгууламжтай уялдуулан нэгдсэн төлөвлөлт хийх, барилгын фасадыг орчны барилгуудтай уялдуулан дэлгээс зургаар харуулах, - Барилгын дээвэр, ханын элементэд шинэ дэвшилтэт технологи ашиглах, төлөвлөж буй барилгын эрчим хүчний хэрэглээний 10-аас доошгүй хувийг сэргээгдэх эрчим хүч ашиглах технологийн шийдлийг тусгах, - Барилгын дээвэр, ханын элементэд шинэ дэвшилтэт технологи ашиглах, барилга байгууламж нь өөрийн нөөц эх үүсгүүр, сэргээгдэх эрчим боломжтой төлөвлөх, барилгын гадна фасад, талбайн гэрэлтүүлгийг цогцоор төлөвлөх, - Үндэсний уламжлалт хэв маягийг төлөвлөлтийн шийдэлд шингээсэн байх, - Орчны барилгуудын газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварыг судалж "Газар хөдлөлийн бичил мужлалын зураг ашиглах норм ба дүрэм" БНбД 22-04-16-г баримтлан төлөвлөх, галын машин чөлөөтэй зорчих боломжийг гаргах, - Галын аюулаас хамгаалах шаардлагыг мөрдөх, гал илрүүлэх болон унтраах зориулалттай автомат систем төлөвлөх, одоо байгаа барилгын гал тэсвэршилт болон хийцлэлийн дүгнэлтийг үндэслэн төлөвлөж буй барилгад тохиромжтой хийцийг сонгон төлөвлөх, - Инженерийн шугам сүлжээг хамгаалах, хүчитгэх арга хэмжээг зураг төсөлд тусгах, - Барилгын хаяг дугаар, гадна зар сурталчилгааны байгууламжийн харьцаа болон байгуулалтыг гудамжны дэлгээс зураг, нүүр тал, хажуу талуудын зураглал дээр тусгах, - Хог хаягдлыг цуглуулах, ангилан ялгах, тээвэрлэх зориулалт бүхий талбайтай байна. - Тэсэрч дэлбэрэх бодис, шатамхай шингэн, аюултай хог хаягдлын агуулах гэх мэт хүн амын аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэхээс бусад аж ахуй үйлдвэрлэл төлөвлөх.

...ЛЛИЙН ХОТ БАЙГУУЛАМЖ...
ХӨГЖЛИЙН ГА...
...ЙН АРХИТЕКТОРЫН ...
27 03 сарын 11 өдөр

		- Хот байгуулалтын тухай хуулийн 12.8-д заасны дагуу төлөвлөх боломжтой, - Газар доорх болон дээрх инженерийн шугам сүлжээ эзэмшигчидтэй зөвшилцөн шугам сүлжээг өөрсдийн хөрөнгөөр зөөж шилжүүлэх, асуудлыг шийдвэрлэсний дараа загвар зураг боловсруулах, - Цэвэрлээгүй хаягдал бохир ус болон хог хаягдал хаях, хаягдлын сан байршуулахгүй байх.
10	Талбайн өндөржилтөд тавигдах шаардлага	- Улаанбаатар хотын нэгдсэн өндөржилтийн төлөвлөлт болон нэгж хорооллын авто замын улаан шугам, өндөржилтийн төлөвлөлттэй уялдуулан төлөвлөлтийн талбайд нэгдсэн өндөржилт төлөвлөлт хийх.
11	Инженерийн шугам сүлжээнд тавигдах шаардлага	- Инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвасын холбогдох норм дүрэм, стандартыг баримтлан төлөвлөж, хамгаалалтын дэглэмийг мөрдөн ажиллах - Инженерийн шугам сүлжээний барилга байгууламжийг эдэлбэр газарт багтаан, хамгаалалтын дэглэмийн дагуу зай хэмжээг тооцон, хөрш залгаа эдэлбэр газарт нөлөөлөхгүйгээр төлөвлөн эх загвар зурагт тусгах. - одоо байгаа шугам сүлжээний хэвийн байдлыг хангах, засвар үйлчилгээ хийхэд саадгүй байхаар төлөвлөх
12	Инженерийн бэлтгэл арга хэмжээ (үерийн хамгаалалт, далан, суваг, шуудуу, зайлуулах шугам сүлжээ)	- Барилга байгууламжийг төлөвлөхдөө тухайн газрын гадаргууд өндөржилтийн хэмжилт хийх, үер, хөрсний нуралтаас хамгаалах бэхэлгээ, далан, суваг, гүүр, гарц, зам, талбай барьж байгуулах урьдчилсан арга хэмжээг тусгах, - эдэлбэр газарт байр зүйн зураглалын тодруулалт хийлгэх, газар доорх болон дээрх шугам сүлжээг тодруулсны үндсэн дээр зураг төслийг боловсруулах, - барилгажих талбайд инженерийн шугам сүлжээ таарсан тохиолдолд холбогдох газартай зөвшилцөж, шилжүүлэх боломжтой эсэхийг тодруулсны дараа загвар зураг төслийг боловсруулах бөгөөд өөрийн хөрөнгөөр шийдвэрлэнэ. - Газрын доорх болон гадаргуугийн ус ашиглах, зайлуулах арга хэмжээг орчны төлөв байдалтай уялдуулан талбайн хэмжээнд иж бүрэн шийдэх, - Газрын ±0.00 төвшнөөс доош төлөвлөж буй байгууламжид гадаргын ус орохоос сэргийлж, ус зайлуулах систем төлөвлөх
13	Барилгажилтын улаан шугам	Магадлал хийлгэсэн ажлын зургийн дагуу барилгын тэг тэнхлэг тавиулж, барилгын ажлыг эхлүүлнэ.
14	Захиалагчийн нэр, албан тушаал, утас	Байгаль орчин, аялал жуулчлалын яам; Утас: (976) 26 61 71;

Анхааруулга:

1. Барилга барих явцад хүрээлэн буй орчны байгалийн тогтоц, өмнө хийгдсэн тохижилт, зам талбай, ногоон байгууламжийг хамгаалах ба хэрэв хөндвөл нөхөн сэргээх.
2. Өндөр барилгын бүсчлэлд талбайн хэмжээнд микросейсмикийн үнэлгээ гаргуулах, цогцолбор барилгын инженерийн хангамж, шугам сүлжээ, дэд бүтцийн техникийн нэгдсэн шийдлийг шийдвэрлэх.
3. Хуучин барилга, байгууламжийг зайлшгүй буулгах, зөөх, засварлах, шаардлагатай бол энэ тухай эрх бүхий байгууллагын албан ёсны техникийн дүгнэлт (акт), шийдвэрийг хувийн хэрэгт хавсаргах.
4. Төлөвлөлтийн хязгаар нь барилга байгууламжийн гадна хийцийг хэтрүүлж болохгүй хил бөгөөд тоон утга (м, м^2, м^3)-аар илэрхийлэгдэхгүй болно.
5. Архитектур төлөвлөлтийн даалгавар нь Барилгын тухай хуулийн 35.1.3-т заасны дагуу барилга байгууламжийн байршлыг тодорхойлж буй баримт бичиг бөгөөд Зураг төсөл зохиогчоос архитектурын онцгой шийдэл, дэвшилтэт технологи, төлөвлөлтийн санал, санаачилга бүхий загвар зургийг ирүүлсэн тохиолдолд хянан батлах боломжтой зөвлөмж захиргааны акт юм. Барилгын тухай хуулийн 4.1.41-д заасан үе шатны ажлуудад батлагдсан загвар зургийг үндэслэнэ.
6. Шаардлагатай тохиолдолд нарны эзэвэрлэлтийг орчны барилга байгууламжийн хамгийн их нөлөөлөлд өртөх хэсэгт норм хангаж байгааг нарийвчлан дүгнэлт гаргах бөгөөд хийсэн аргачлалаа файлаар өгч зөвшилцөнө. Мөн төлөвлөж буй барилгын 3 хэмжээст файл болон

ТӨЛӨВЛӨЛТИЙН АЖЛЫН АЛБА
24 оны 03 сарын 11 өдөр

Ерөнхий төлөвлөгөөний файлыг загвар зураг батлах үед хот байгуулалтын менежментийн нэгдсэн сангийн жижүүрлэлтийг баяжуулах үүднээс хүлээлгэн өгнө.

7. "Нийслэлийн хэмжээнд мөрдүүлэх стандарт, шаардлага" UCS 0901B:2020, UCS 0902B:2020, UCS 1603C:2020, UCS 1601B:2020, UCS 1601C:2020, UCS 0903B:2020, UCS 0001-01:2019, UCS 0001-02:2019, UCS 1602B:2020, UCS 1602C:2020, UCS 0002-02:2019, UCS 1901B:2020, UCS 1403C:2020, UCS 1404C:2020-г тус тус мөрдөх.
8. Архитектур төлөвлөлтийн даалгавар батлагдсанаас хойш 2 жилийн хугацаанд хүчинтэй бөгөөд загвар зураг батлагдсанаар цаашид загвар зургийн хүчинтэй хугацаанд барилга угсралтын ажлыг гүйцэтгэнэ.
9. Газрын эрх цуцлагдсан болон хугацаа сунгагдаагүй тохиолдолд энэ актыг хүчингүйд тооцно.

ХЯНАСАН
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА С.ДАЛАНЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ХОТ БАЙГУУЛАЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Г.БӨРТЭЦЭЦЭГ

ХОТ БАЙГУУЛАЛТ,
ХӨГЖЛИЙН ГАЗАР

ХОТЫН АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБА
04 оны 03 сарын 11 өдөр

ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЯЗГААРЫН СХЕМ ЗУРАГ

(Дугаар: МЗХ2024/00-083 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгаврын хавсралт)

Байршил	Эзэмшигч	Зориулалт
Хан-Уул дүүргийн 23-р хороо	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Байгаль орчны шинжилгээний төв лабораторийн барилга

Масштаб 1:${scale}* *Тусгаа: EPSG:${projcs} *(Архитектур төлөвлөлтийн даалгаврын хамт хүчинтэй.)*

ТАНИХ ТЭМДЭГ

- Одоо байгаа барилга
- Төлөвлөлтийн хязгаарын хэмжээ
- Газрын хэмжээ
- Цэвэр усны шугам
- Бохирын шугам
- Дулааны шугам
- Холбооны шугам
- Төрийн шугам

ТОДОРХОЙЛОЛТ

1	*Төлөвлөж буй байршил*
2	*Сургалт судалгааны барилга*
3	*Төлөвлөж буй мэргэжил, сургалт, үйлдэрийн төв*
4	*Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг*
5	*Авто зам, талбай*

ОЛГОСОН ТАЛБАЙН ТОДОРХОЙЛОЛТ

Эдэлбэр газар (м2)	13828.0
БАРИЛГАЖИХ ТАЛБАЙ (м2)	2955.5

ЭРГЭЛТИЙН ЦЭГҮҮДИЙН СОЛБИЦОЛ

№	X	Y	тал=урт(m)
1	637266.204	5303252.123	1-2=59.915
2	637211.838	5303226.938	2-3=67.540
3	637240.616	5303165.836	3-4=60.784
4	637296.631	5303189.436	4-1=69.681

ТӨРИЙН АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБА
24 оны 05 сарын 11 өдөр

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР
Хот төлөвлөлтийн хэлтэс

Хан-Уул дүүрэг, 23-р хороо, Арцатын ам /17100/,
Нэадамчдын зам 1200
Цахим хуудас: www.uda.ub.gov.mn, www.ebarilga.ub.gov.mn
Утас: 11-324975

БАТЛАВ.
УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ..... Ц.АМАРСАНАА

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Олгосон огноо: 2024/11/27 Дугаар № 574/2024 Улаанбаатар хот

1. Техникийн нөхцөл хүссэн иргэн, хуулийн этгээдийн нэр хаяг:	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
2. Барилгын байршил,мэдээлэл:	Хан-Уул дүүрэг, 4-р хороо, Арцат апартментийн баруун хойно, Байгаль орчны шинжилгээний төв лаборатори
3.Холбох нөхцөл	
4.Холбогдох цэг, байршлын зураг, схем, техникийн өгөгдөл:	10ж магистраль, ДХ10195 худгаас холболттой өөрийн салаа шугамын хүчин чадлыг тооцон өргөтгөж, өмнө олгосон 408/2023 тоот техникийн нөхцөлтэй уялдуулан ХЦТ-ийн дараагаас холбогдох -Холболтын цэг дээр байх түрэлт 6 м -Шугамын статик даралт 25 м.у.б -Буцах шугамын даралт 3.8 ата -Гадна агаарын тооцоот температур -39 0 C -Температурын график 95/65 0 C
5. Дулааны эрчим хүчний хэрэглээ:	**Нийт : 0.56 Гкал/цаг** А.Халаалт 0.40 Гкал/цаг Б.Хэрэгцээний халуун ус 0.16 Гкал/цаг В.Салхилуулга 0.00 Гкал/цаг
6. Дулаан дамжуулах, түгээх сүлжээ, дулаан дамжуулах төв, дулааны үзель болон тоноглолд тавигдах шаардлага:	6.1 Төлөвлөж буй барилгад төвлөрсөн дулаан хангамжийн техник ашиглалтын шаардлага хангасан холигч насосны үзель суурилуулах. "Гадна дулаан хангамж" БНбД 41-02-05 -ийн 10.7-д заасны дагуу Дулаан хангамжийн хаалттай системийн үед халуун ус ба халаалтын хамгийн их дулааны ачааллын харьцаанаас хамааруулан ус халаагчийн холболтын схемийг сонгох. 6.2. Горим ажиллагаа доголдож хүндрэлтэй нөхцөл үүссэн үед өөрсдийн барилгын дулаан хангамжийн найдвартай байдлыг хангах нэмэлт эх үүсвэр төлөвлөж байгын бэлэн байдлыг хангаж ажиллах. 6.3 Барилгын дотор халаалтын системд балансын хаалт, термостат суурилуулах. 6.5 Техникийн нөхцөлийн дагуу шинээр суурилуулах шугам хоолой, тоноглолууд нь өмнө ашиглагдаж байгаагүй шинэ байх, сүүлийн үеийн байгаль орчинд эзлтэй, дэвшилтэт техник, технологи байх.
7.Тоолуур, хянах, хэмжих хэрэгсэлд тавигдах шаардлага:	7.1. Дулааны эрчим хүчний тооцоонд "Хэмжил зүйн тухай хууль"-ийн 9, 10 дугаар зүйлийн дагуу Стандарт, хэмжил зүйн газрын загварын туршилт, улсын баталгаажуулалтад хамрагдаж, улсын бүртгэлд бүртгэгдсэн, Монгол улсад ашиглахыг зөвшөөрсөн, дулааны тоолуурын лабораториор шалгагдсан, баталгаажуулалтын гэрчилгээ бүхий тооцооны хэмжих, тооцох хэрэгслийг суурилуулна. 7.2. "Дулааны эрчим хүчийг хэмжих, тооцох дүрэм"-ийн 6 дугаар бүлэгт заасны дагуу хангагч "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-иас дулааны эрчим хүчийг хэмжих тооцох хэрэгслийг суурилуулах техникийн нөхцөл авах

8.Зураг төсөл боловсруулахад тавигдах шаардлага:

8.1 Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолоор батлагдсан "Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм"-ийн 2.2-т заасан дамжуулах төв, дулааны шугамын хамгаалалтын зайг мөрдөн, барилга байгууламжийг төлөвлөх, мөн дүрмийн 2.6, эрчим хүчний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-т заасны дагуу хамгаалалтын зурвас дотор барилга байгууламж, гэр хашаа барих, барилгын тохижилт, зам талбай, зогсоол, бусад байгууламж төлөвлөхгүй байх.

8.2. Дулааны шугамын трасс сонголт, холболтыг хийхдээ шугам эзэмшигч, шугамын трасс дагуух газар эзэмшигчтэй зөвшөөрөлцөх, бусдын эзэмшил газар шугамын трассыг сонгохгүй байх.

8.3. Төвлөрсөн дулаан хангамжид холбогдох явцад трассын дагуух зам талбай, ногоон байгууламжийг сэргээх, тохижилт хийх болон дулаан хангамжийн систем, узель ба дотор системийн угаалт, шахалтын туршилт хийх зардлыг төсөвт тусгах.

8.4. Гадна дулааны шугам хоолой болон узелийн тоноглолыг дулааны алдагдлын норм норматив нийцсэн материалаар техник ашиглалтын шаардлагын дагуу дулаалахаар зураг төсөвт тусгах.

8.5. Дулааны шугам сүлжээ авто зам доогуур өнгөлох нөхцөлд нэвтрэх сувгатай байхаар төлөвлөн, зураг төсөвт тусгах.

8.6. Гадна дулааны шугам сүлжээний зураг төслийг боловсруулан хангагч байгууллага "Улаанбаатар Дулааны Сүлжээ" ТӨХК-тай зөвшилцөн, хянуулж, батлуулан 1%-г хүлээлгэн өгөх.

9.Дагаж мөрдөх хууль, дүрэм, журам:

9.1. Дулааны шугам сүлжээ, тоноглолын зураг, төсөв боловсруулах, барилга угсралт, туршилт, тохируулгын ажлыг гүйцэтгэх, ашиглалтад оруулахад дараах хууль, дүрэм, журам, барилгын норм ба дүрэм, стандартуудыг мөрдөж ажиллана.

9.1.1. Эрчим хүчний тухай хууль
9.1.2. Барилгын тухай хууль
9.1.3. Хэмжил зүйн тухай хууль
9.1.4. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм", "Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм"
9.1.5. Дэд бүтцийн сайдын 2003 оны 125 дугаар тушаалаар батлагдсан "Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм"
9.1.6. Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2010 оны 127 дугаар тушаалаар батлагдсан "Уурын ба ус халаах зуухыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм"
9.1.7. Эрчим хүчний сайдын 2014 оны 05 дугаар тушаалаар батлагдсан "Уурын ба халуун усны шугам хоолойг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм"
9.1.8. Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 290 дүгээр тогтоолоор батлагдсан Дулаан дамжуулах, түгээх сүлжээний "Холболтын журам"
9.1.9. Барилгын норм ба дүрмүүд

9.2. Эрчим хүчний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Эрчим хүчний дамжуулах шугам, дэд станц нь төрийн өмчлөлд байна", мөн хуулийн 30.1.13-т "нийтийн эзэмшлийн орон сууцны барилга барих тохиолдолд барьсан эрчим хүчний дэд станц, шугам, тоноглолыг түсгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх" гэж заасны дагуу хангагч байгууллагад хүлээлгэн өгөх, шилжүүлэх нөхцөл хангасан тохиолдолд дулааны эрчим хүчээр хангана.

9.3 Эрчим хүчний тухай хуулийн 29.1.9-д "Хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам, дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлөвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж холбох эрхтэй" гэж заасан, мөн хэрэглэгч нь хуулийн 30.1.10-т "түгээх, зохицуулалттай эсхүл зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлөөр өөрийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчийг холбуулах" гэж заасны дагуу бусад хэрэглэгчийг

9.4 Дулааны эрчим хүч хэрэглэх дүрмийн 5.1.20-р заалтын дагуу дулаан дамжуулах 200мм-ийн голчтой болон түүнээс дээш голчтой төв шугам, салаа шугам, түүний анхдагч таслах хаалт нь эрчим хүчний дамжуулах шугам тоноглол тул түүнийг төрийн өмчлөлд шилжүүлнэ. Эрчим хүчний зохицуулах хорооны 2023 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 348 дугаар тогтоолын дагуу 2Ø200мм-ээс дээш голчтой дамжуулах сүлжээг төрийн өмчид шилжүүлэх "Өмч шилжүүлэх гэрээ"-г байгуулж, хэрэгжилт бүрэн хангасан нөхцөлд

10. Техникийн нөхцөл олгосон үндэслэл:

Нийслэлийн ерөнхий архитектор бөгөөд Хот байгуулалт, хөгжлийн газрын даргын 2024 оны 3 сарын 11-ний өдрийн МЗХ2024/00-083 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавар, эскиз зургийг үндэслэв.

11.Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа:

11.1 Энэхүү техникийн нөхцөл олгосноос хойш 2 жилийн хугацаанд буюу 11/27/2026 өдрийг хүртэл хүчинтэй.

11.2. Техникийн нөхцөлийн хугацааг сунгуулах тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2.10-т заасны дагуу хугацаа дуусахаас 2 сарын өмнө хүсэлтээ, баталгаажуулсан зураг төслийн хамт цахим системд ирүүлнэ.

11.3. Тус дүрмийн 2.7-д заасны дагуу техникийн нөхцөлийн хугацааг боломжтой тооцооны дүн гарсан тохиолдолд 1 удаа 1жилийн хугацаатай сунгана.

11.4. Техникийн нөхцөлийн 3 болон 11 дэхь заалт хангагдаагүйгээс хэрэглэгч холбогдоогүй тохиолдолд техникийн нөхцөл олгосон хангагч байгууллага хариуцлага хүлээхгүй.

11.5. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2.13-д заасны дагуу техникийн нөхцөлийг үндэслэн зураг төслийн байгууллагаар барилга угсралтын ажил эхлэхээс өмнө зураг төслөө хийлгэж, холбогдох байгууллагуудаар хянуулж, эрх бүхий байгууллагаар магадлал хийлгэж баталгаажуулсан байна.

11.6. Техникийн нөхцөлийн хугацааг сунгуулах тохиолдолд "Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2.10-т заасны дагуу хугацаа дуусахаас 2 сарын өмнө хүсэлтээ, баталгаажуулсан зураг төслийн хамт цахим системд ирүүлнэ. Хэрэв зураг төслийг батлуулаагүй, мөн баталгаажуулсан зураг төсөл ирүүлээгүй тохиолдолд техникийн нөхцөлийн хүчинтэй хугацааг сунгахгүй.

12.Техникийн нөхцөлийн хүчингүйд тооцох:

12.1 Дараах тохиолдолд энэхүү техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно. Үүнд:

12.1.1. Хүчинтэй хугацаа дууссан;

12.1.2. Энэхүү техникийн нөхцөлийн аль нэг заалт, шаардлагыг биелүүлээгүй

12.1.3. Техникийн нөхцөл авахдаа шаардлагатай өгөгдлүүдийг буруу тодорхойлсон, баримт бичгийг хуурамчаар үйлдсэн;

12.1.4. Олгосон ачааллаас хэтрүүлэн чадал ашигласан, мөн холболтын цэгийг өөрчилсөн тохиолдолд;

12.2. Хугацаа дууссан техникийн нөхцөлөөр зураг төсөл боловсруулах, барилга байгууламжийг дулаанд холбохыг хориглоно.

ЗӨВШӨӨРСӨН.
ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОХ КОМИССЫН ДАРГА,
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР Ш.МӨНХЖАРГАЛ

ХЯНАСАН:
ҮБХ-ИЙН ДАРГА Г.БАЯРСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:
ҮБХ-ИЙН ИНЖЕНЕР Н.САНЖААЖАМЦ

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН ТАЛААРХ ТЭМДЭГЛЭЛ:

Хүсэлт гаргасан иргэн буюу хуулийн этгээдийг төлөөлж:
Хүлээн авч, техникийн нөхцөлийн шаардлагууд, тухайн техникийн нөхцөл хүчингүйд тооцох заалттаг танилцсан эсэх

☑ ТИЙМ ☐ ҮГҮЙ

Нэр ..батчин..... Гарын үсэг .....

Регистрийн дугаар .....
Холбоо барих 99088142
Огноо 2024 он 12 сар 13 өдөр

УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Дугаар 01/06381/24

2024 оны 12 сарын 12 өдөр Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий мэдээлэл

1.1	**Хүсэлтийн дугаар**	*241200249*	
1.2	**Хэрэглэгчийн нэр, регистр:**	*БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ, РД:9085084*	
1.3	**Хэрэглэгчийн байршил:**	*Улаанбаатар Хан-Уул 23-р хороо 0 тоот*	
1.4	**Ажил үйлчилгээний зориулалт:**	*Лаборатори*	
1.5	**Техникийн нөхцөл олгох үндэслэл:**	*1.5.1) Газар ашиглах эрхийн 2022-06-07-ны нэгж талбарын 1781113022 дугаартай гэрчилгээ* *1.5.2) Архитектур төлөвлөлтийн 2024 оны 03 сарын 11-ны өдрийн МКХ2024/00-083 дугаартай даалгавар, батлагдсан эскиз зураг* *1.5.3) Монгол улсын Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2024-11-13-ны өдрийн 03/5361 тоот албан бичиг*	
1.6	**Техникийн нөхцөлийн ангилал:**	*Шинэ холболт*	
1.7	**Суурилагдсан хүчин чадал**	*540 кВА*	*(Таван зуун дөчин кВА)*
1.8	**Хүчдэлийн түвшин**	*380В*	

Хоёр. Холболтын цэг

2.1	110/35/10 кВ-ын Арцат, Яармаг дэд станцаас 10 кВ-ын Уяачид, Нүхт фидерийн ХТП-5668 дэд өртөөнөөс ХТП-6542 хоорондох кабель шугамыг оруулж гарган холбогдох 01/03855/24 тоот техникийн нөхцөлийн /БОАЖЯ-нд олгосон/ дагуу баригдах ХТП-ний 10 кВ-ын I ба II секцээс кабель шугам татаж шинээр баригдах дэд өртөөг /ХТП/ тэжээх.
2.2	Шинээр баригдах ХТП дэд өртөөний 10 кВ талын I ба II секцнээс кабель шугам татаж 110/35/10 кВ-ын Арцат дэд станц, ХБ-86-гийн 10 кВ-ын Гарьд А, Б фидерийн ХТП-10191 дэд өртөөний 10 кВ талын I ба II секцэнд холбох.

Гурав. Тоолуур, хэмжих хэрэгсэл:

3.1	Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг-Стандарт, хэмжилзүйн газрын загварын туршилт орсон, ашиглахыг зөвшөөрч, баталгаажуулсан байх.

3.2	Дэд өртөөний 0.4 кВ талын ерөнхий оруулгуудад УБЦТС ТӨХК-д ашиглагдаж байгаа ухаалаг тоолуурын системд холбогдон ажилладаг, DLMS протоколыг дэмждэг, 4G модемтой, тасалж залгах команд өгөх боломжтой, 3 фазын ухаалаг тоолуур, гүйдлийн трансформатор болон тоолууранс өгөгдөл цуглуулж дамжуулах зориулалттай, 4G модемтой концентраторыг тусгай хайрцагт суурилуулах.
3.3	Ажлын зураг төслийг зөвшилцөх шатанд суурилуулах тоолуурын төрөл, марк, схемийг УБЦТС ТӨХК-аар хянуулсан байх.

Дөрөв. Тусгай заалтууд:

4.1	Олон улсын стандартын шаардлага хангасан, алдагдал багатай 2*630 кВА чадалтай, 10/0.4 кВ-ын хүчдэлийн, хүчдэл тохируулгын 5 шатлалтай трансформатор бүхий дэд өртөөг /ХТП/ өөрийн эзэмшлийн газарт шинээр барих.
4.2	Энэхүү техникийн нөхцөл нь дараах нөхцөл, шаардлагуудыг хангасан тохиолдолд хүчинтэй болно. 4.2.1) Энэхүү техникийн нөхцөлийн хүчинтэй байх хугацаанд түгээх сүлжээнд холбогдсон байх шаардлагатай. 4.2.2) Эх үүсвэр дэд станц, шугам тоноглол хэт ачаалагдсан тул түгээх сүлжээнд 2024, 2025 онд цахилгаан ачаалал нэмэх боломжгүй. Шугам сүлжээнээс 2026 онд 100 кВА чадлаас хэтрэхгүйгээр хангана. 4.2.3) Цаашид эх үүсвэр дэд станц, шугам тоноглолын хүчин чадлыг нэмэгдүүлж өргөтгөл шинэчлэлийн ажил хийгдсэний дараа олгосон бүрэн чадлыг үе шаттайгаар ашиглах боломжтой юм.
4.3	Тус байршилд 10 кВ-ын кабель шугам байгаа тул цахилгаан дамжуулах шугамын хамгаалалтын зурвасыг чөлөөтэй байлгахыг анхаарах.
4.4	Гадны ээмшлийн дэд станц, шугам тоноглолоос холбогдох тохиолдолд тус дэд станц, шугам тоноглолын ээмшигчээс зөвшөөрөл авсан байх.
4.5	Өвлийн их ачааллын горимд тус цахилгаан ачааллыг залгах боломжгүй тул жил бүрийн 11-р сарын 01-ээс 03-р сарын 01 хүртэл ахуйн хэрэглээнээс бусад цахилгаан ачааллыг нэгдсэн системийн зохицуулалтаар хязгаарлах арга хэмжээ авах нөхцөлөөр энэхүү техникийн нөхцөлийг олгов.
4.6	Шинээр баригдах дэд өртөөний 10 кВ талын хуваарилах байгууламж нь 10-аас доошгүй ячейк суурилуулсан байх.
4.7	Дэд өртөөний барилга нь тоосгоор баригдсан байх шаардлагатай бөгөөд цаашид өргөтгөх боломжтой байхаар барих.
4.8	Одоо ашиглагдаж байгаа ХТП-ны 10 кВ талд шинэ ячейк суурилуулах зай байхгүй тохиолдолд тухайн дэд өртөөний барилгыг өртгөтгөх.
4.9	Галын хор, щит, самбар, пунктыг галын аюулгүйн дүрэмд заагдсаны дагуу байрлуулж, галын аюулгүй байдлыг хангах.
4.10	Шугам, дэд өртөөний гүйцэтгэлийн зургийг гаргаж, ашиглагч байгууллага УБЦТС ТӨХК-д хүлээлгэн өгөх, гүйцэтгэлийн зургийг гаргахдаа шугамын холболтын муфтуудыг заасан мөн бусад инженерийн шугам сүлжээ, авто замтай огтолцсон хэсгийн зүсэлтийг тусгах.
4.11	10/0.4 кВ-ын дэд станцын 10 кВ-ын хуваарилах байгууламж нь трансформаторын хүчин чадлаар тооцогдсон таслах залгах тоноглол, хэт хүчдэл тусгаарлагч, гал хамгаалагч болон хүчний трансформатораар тоноглогдсон байна.
4.12	Дэд өртөөний 0.4 кВ талын хуваарилах байгууламж нь хэт хүчдлийн хамгаалалт, ихсэх гүйдлийн, хэт ачааллын, хүчдэл ихсэлт бууралтын, фазын нойл тасралт,

фазын дараалал алдагдалтаас сэргийлсэн хамгаалалтуудаас тоноглогдсон байна.

4.13 Түгээх сүлжээний үндсэн шугам нь хэт урт, ачаалал ихтэйгээс шалтгаалан хэрэглэгчид очих эрчим хүчний чанар, стандартын шаардлага хангахгүй тохиолдолд хүчдэл өргөх төхөөрөмж суурилуулах болон техникийн нэмэлт арга хэмжээнүүдийг УБЦТС ТӨХК-тай хамтарсан хэмжилт туршилтын үндсэн дээр хэрэгжүүлнэ. Нэмэлт ажилтай холбоотой гарах зардлыг хэрэглэгч бүрэн хариуцна.

4.14 Дэд өртөөний бүх тоноглол, гаргалга кабель шугамууд болон агаарын шугамын тулгуур бүрт НСД, ААД, ТАД-д заагдсаны дагуу хаягжилт, плакатжуулах ажлыг гүйцэтгэсэн байна.

4.15 УБЦТС ТӨХК-ийн эзэмшлийн шугам дэд станцад хийгдэх өргөтгөлийн ажлыг харьяа түгээх төвөөр гүйцэтгүүлэх.

4.16 Цахилгаан хангамжийн I зэрэглэлийн шугамаас холбогдож байгаа тул цахилгаан эрчим хүч тасарсан үед тэжээх нөөц эх үүсгүүр /дизель генератор/ суурилуулах.

4.17 Шугам тоноглол нь 2 талын цахилгааны эх үүсвэрээс тэжээлтэй болон автомат сэлгэн залгагч төхөөрөмж суурилуулсан мөн аваарийн нөөц тэжээлийн эх үүсвэр /дизель, генератор/-тэй бол харьяа түгээх төвтэй Шуурхай ажиллагааны гэрээ байгуулах.

4.18 Хаалттай дэд өртөө рүү оруулж гаргах 6-10 кВ-ын кабель шугамуудыг зураг төсөл боловсруулах шатанд 2 өөр трасс сонгож зөвшилцөх.

4.19 Хаалттай дэд өртөө рүү орж гарсан 6, 10 кВ-ын кабель шугам нь УБЦТС ТӨХК-ийн найдвартай ажиллагааны горим схем үүсгэдэг гол магистраль кабель шугам тул тус компанийн үндсэн хөрөнгө болохыг анхаарна уу.

4.20 Хаалттай дэд өртөөний газардуулга, аянга зайлуулагч болон шугам тоноглолыг норм дүрэм, зураг төслийн дагуу хийж гүйцэтгэх, холбогдох газраар шалгуулж протокол авсан байх.

4.21 Цахилгаан дамжуулах шугамын трассыг одоо байгаа болон ойрын хугацаанд баригдахаар төлөвлөгдсөн бусад шугамын гаргалгаа, трасстай аль болох огтлолцохгүй байхаар төлөвлөн, зураг төслийн шатанд бусад инженерийн байгууламж хариуцсан байгууллагуудтай зөвшилцөн сонгох.

4.22 Техникийн нөхцөлийн дагуу шинээр суурилуулах тоноглолууд нь өмнө ашиглагдаж байгаагүй шинэ байх, кабель шугам, трансформаторууд нь сүүлийн үеийн байгаль орчинд ээлтэй, дэвшилтэд техник технологи бүхий байх. Нэгдсэн сүлжээний дүрэмд заасны дагуу ±10%-ийн хүчдлийн хэлбэлзэлд хэвийн ажиллах.

4.23 Шинээр баригдах цахилгаан дамжуулах кабель шугам нь:

4.23.1) Шинээр татах 10 кВ-ын кабель шугам нь MNS 6819:2015 стандартын шаардлагыг хангасан байх.

4.23.2) Шинээр татах 10 кВ-ын кабель шугамын хөндлөн огтлолыг хэрэглээ ачаалалтай уялдуулан зураг төслийн шатанд тооцоогоор сонгох, ашиглагч "УБЦТС" ТӨХК-тай зөвшилцөх.

4.23.3) Шинээр татах кабель шугам нь 10 кВ-ын хүчдлийн түвшинд ажиллах, гадна орчны температур -15 хэт байхад угсралт хийх боломжтой байх.

4.24 Түгээх сүлжээний төлөвлөлт, горимын онцгой ач холбогдол бүхий нийтийн сүлжээ, магистраль шугам үүсгэхээр газарт техникийн нөхцөл олгосон тул шинээр баригдах дэд станц, цахилгаан дамжуулах шугам, тоноглолоос хангагч байгууллага нь горимын найдвартай ажиллагааг хангах зорилгоор бусад иргэн, хуулийн этгээдэд техникийн нөхцөл олгохыг анхаарна уу.

4.25 Өөрийн дэд станц, шугам тоноглолоос хангагчийн зөвшөөрөлгүйгээр бусад хэрэглэгчийг холбосон тохиолдолд цахилгаан хангамж, хэрэглээг түдгэлзүүлнэ.

4.26 Өвлийн их ачааллын улиралд эрчим хүчний системийн горим ажиллагааг хангах үүднээс урьдчилан мэдэгдэлгүйгээр хязгаарлалт хийж болзошгүй тул нөөц эх үүсгүүрийг бэлэн байдлыг хангаж ажиллахыг анхаарна уу.

4.27 Цахилгаан эрчим хүчний өвлийн их ачааллын улирал эхэлж байгаатай холбогдуулан энэхүү техникийн нөхцөлийн дагуу 2025 оны 03 сарын 01-нээс хойш сүлжээнд холбогдохыг анхаарна уу.

4.28 Төлөвлөж байгаа барилгын талбайд дараах кабель шугам огтлолцсон тул батлагдсан зургийн дагуу трасс өөрчлөн зөөх Үүнд:

4.28.1) 110/35/10 кВ-ын Арцат дэд станцаас РП-86 хооронд 2 ширхэг 10 кВ-ын кабель шугам.

4.28.2) Цахилгаан дамжуулах кабель шугамын зөөх байршлын зургийг эрх бүхий байгууллагаар хийлгэн Нийслэлийн барилга, хот байгуулалт төлөвлөлтийн газраар батлуулж, мэдээллийн санд оруулсан байх, схем холболт, хүчин чадлыг тус компаниар хянуулах.

4.28.3) Нэг трассад байгаа кабель шугамуудыг Цахилгаан байгууламжийн дүрэм, ТАД, ААД-ын заалтуудыг хангасан инженерийн сувагчлалын байгууламж, кабелийн блок барьж байршуулах.

4.28.4) Инженерийн сувагчлалын байгууламж, кабелийн блок барих ажлын шийдэл төслийг тус компанийн Техникийн бодлого хэлтэстэй зөвшилцөх.

4.28.5) Кабель шугамыг шилжүүлэн зөөх хэсэгт байгаа муфтьны байршлын тодруулгыг харьяа ашиглалт засварын төвөөс авч, шугамыг муфтьнаас муфтьны хооронд зөөх асуудлыг барилга угсралтын ажлын зураг төслийн шатанд УБЦТС ТӨХК-тай зөвшилцөж гүйцэтгэх.

4.28.6) Шинээр татах кабель шугам нь авто зам болон тохижилттой зам талбайгаар хөндлөн гарах тохиолдолд кабелийг ган хоолойнд сувлэх ба тохижилттой зам талбайд авах боломжтой хавтан суурилуулах.

4.28.7) Батлагдсан зургийн дагуу зөөж шилжүүлэх шугамын трасс өөрчлөгдөх тохиолдолд харьяа ашиглалт засварын төвөөс дахин тодруулга авч УБЦТС ТӨХК -тай зөвшилцөх.

4.28.8) Газар шорооны ажил хийж байхдаа кабель шугамыг гэмтээсэн тохиолдолд тухайн кабель гэмтээд зогсохгүй бусад тоног төхөөрөмж гэмтэх, хэрэглэгчдийн цахилгаан хэрэгсэл шатах зэрэг ноцтой зөрчилүүд үүсэх бөгөөд гарсан төлбөрийг буруутай байгууллага ААНэгж, иргэн хариуцна.

4.28.9) Угсралтын ажлын явцад тус компанийн харьяа ашиглалт засварын төвөөр хяналт тавиулж холбогдох баримтыг бүрдүүлсэн байх.

4.28.10) УБЦТС ТӨХК-ийн эзэмшлийн бус цахилгаан дамжуулах шугам, тоноглолыг шилжүүлэн зөөх тохиолдолд эзэмшигчээс зөвшөөрөл авах ба бусад инженерийн байгууламж хариуцсан байгууллагуудтай зөвшилцсөн байх.

4.28.11) Шилжүүлэн зөөсөн болон шинэчилсэн цахилгаан дамжуулах агаарын болон кабель шугам, тулгуур, дэд өртөө бусад тоноглолыг УБЦТС ТӨХК- ийн харьяа ашиглалт засварын төвд актаар хүлээлгэн өгөх.

